



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/226

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", 29.2, Дайчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйл, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын "Орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах тухай" маш нууц 160-181 дүгээр удирдамж, 2020 оны "Дайчилгааны бэлэн байдлыг хангах тухай" маш нууц №600/02 дугаар стратегийн удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабыг "Байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөө"-г хууль, журам зааврын дагуу боловсруулан 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулахыг Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

2. Төлөвлөгөө боловсруулах явцад төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцын горимыг чанд баримтлан, хүн нэг бүрээр нууцын баталгаа гаргуулахыг Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер /хошууч Ж.Нямжаргал/-д даалгасугай.

3. Төлөвлөгөө боловсруулан, батлуулах ажлын хэсэгт шаардагдах зардалд 1 830 000 төгрөг /нэг сая найман зуун гучин мянган/-ийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/226 Ch
20 1280

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар
сарын 10-ны өдрийн А/226 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын ангилал	Тоо	Төсвийн дүн	Хянасан
1	Улаанбаатар хот явах шатах, тослох материалын зардал	3000 км	1 080 000 төг	
2	Байр, хоолны зардал	3 хүн 5 хоног	750 000 төг	
3	Нийт зардал		1 830 000	

1. Явах км $3000 \text{ км} * 18 \text{ литр} / 100 * 2000 = 1\ 080\ 000 \text{ төг}$

2. Байр хоолны зардал $3 \text{ хүн} * 5 \text{ хоног} * 50000 \text{ төг} = 750\ 000 \text{ төг}$

Нийт дүн= 1 830 000 төг

-оОо-